



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх
ажлыг эрчимжүүлэх тухай

Улсын хэмжээнд 2017 оны байдлаар 82 удаагийн ой, хээрийн түймэр гарч /урьдчилсан байдлаар/ 38905.8 га ой, 27654.5 га хээр, нийт 66564 га талбай түймэрт олон өртсөн байна. Цаашид түймрийн аюулын түвшин идэвхжиж бүс нутгийг хамрах урьдчилсан төлөвтэй байна. Иймд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.6 дахь заалт, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 13.1.14, 13.1.30 дахь заалтууд, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор дараах албан даалгаврыг гаргаж байна.

Нэг . Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

1. Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Гамшгийн тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиуд, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоол, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны "Ой, хээрийн түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө" 48\267-А дугаар хамтарсан тушаал, Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/70 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх;

2. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлуудыг хариуцсан нутаг дэвсгэрийн сум, дүүрэг, баг, хороонд зохион байгуулж, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, байгаль орчны чиглэлийн харьяа газруудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэвлэл мэдээллээр сурталчлах, иргэдийн оролцоог идэвхжүүлэх, хяналт тавих;

3. Түймрийн аюултай үед ойгоос мод бэлтгэх, ойн дагалт нөөцийг ашиглах бусад үйл ажиллагааг Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2. 18 дахь заалтад заасны дагуу хязгаарлах захирамж гарган хэрэгжилтэд хяналт тавьж ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэр гарсан үед хүн хүч, техник хэрэгслийг дайчлан Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасны дагуу

унтраах ажлыг шуурхай зохион байгуулах, унтраахад шаардагдах зардал, багаж хэрэгсэл, хүнсний нөөцийг хангахад дэмжлэг үзүүлэх;

4. Ойн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ой, хээрийн түймрийн шалтгаан, эзэн холбогдогчийг тогтоох, ойд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглох асуудлаар Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах;

Хоёр. Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаад, Сав газрын захиргаадын дарга нарт:

1. Түймрийн аюулын зэрэг гурав болон түүнээс дээш болох хугацаанд түймрийн эргүүл, хяналтын ажлыг зохион байгуулах, орон нутгийн Цаг уур, орчны шинжилгээ болон Онцгой байдлын байгууллагуудтай хамтран нэгдсэн зохион байгуулалтанд орж, зориудаар үүлэнд нөлөөлөх зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой зохион байгуулах, цагийн байдлын тухай мэдээлэл солилцож байх жижүүрийг тогтмол ажиллуулах;

2. Түймрийн жижүүрийг мэргэжлийн удирдлагаар хангаж, хариуцлагажуулах, үүрэг, биелэлтийг ажлын үр дүнгийн гэрээнд тооцож дүгнэх, өөрийн нутаг дэвсгэрт гарсан түймрийн тухай мэдээллийг байгааль хамгаалагч нараас шууд авч, үнэн зөв тодорхой мэдээлэл өгөх, ой хээрийн түймэр гарсан тохиолдолд хариуцлагатай жижүүрийг холбоо, харилцааны хэрэгслээр хангаж, мэдээ, мэдээллийг яамны түймрээс урьдчилан сэргийлэх хариуцлагатай жижүүрийн 93028004, 261726, 267283 утсаар өдөр бүр тогтмол, шуурхай мэдээлж байх;

3. Тухайн бүс нутгийн цаг уурын нөхцөлөөр тогтоосон түймрийн аюулын зэрэглэл гурав ба түүнээс дээш болох үед ойгоос мод бэлтгэх, ойн цэвэрлэгээ, арчилгаа хийх, үр, мөчир бэлтгэх, ойн дагалт нөөц ашиглах, аялал зугаалга зэрэг аливаа үйл ажиллагаа явуулахыг зогсоож, байгаль хамгаалагчдын хяналт шалгалтыг нэмэгдүүлэх;

4. Мэргэжлийн байгууллагын эрх бүхий аж ахуйн нэгж, нөхөрлөлийн үйл ажиллагааг Ойн тухай хуулийн 21, 22 дугаар зүйлд заасан заалтуудыг мөрдөж, байгаль хамгаалагчийн хяналтан дор явуулахыг онцгой анхаарч, хариуцлагын баталгаа гаргуулан ажиллах;

5. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар зохион байгуулж байгаа ажлын үр дүнг нэмэгдүүлж, үйл ажиллагааг орон нутгийн Засаг захиргаа, Онцгой байдал болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах;

6. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд сэрэмжлүүлэг, санамжийг тодорхой давтамжтайгаар явуулж, ойн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлийн гишүүдэд түймрээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга сурталчилгаа явуулах, урьдчилан сэргийлэх ажилд сум дундын болон сумын ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөл, гишүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх;

7. Албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ирүүлэхийг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Цэнгэл/, тайланг нэгтгэн танилцуулахыг Ойн бодлого зохицуулалтын газрын дарга /М.Тунгалаг/ нарт даалгасугай.

САЙД  Д.ОЮУНХОРОЛ